



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/154

Зуунмод

Г Дайчилгаа зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.13, 10 дугаар зүйлийн 10.4.4, 19 дүгээр зүйлийн 19.1, 32 дугаар зүйлийн 32.1.9, Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Гамшгийн үед дайчилгаа зохион байгуулах журам”-ын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод суманд Коронавирусийн халдварын цар тахлын тохиолдол илэрсэнтэй холбогдуулан “Өвөр жанчивлан” рашаан сувиллын байрыг халдвар илэрсэн иргэдийн ойрын болон дам хавьтлыг тусгаарлах зорилгоор дайчилсугай.

2. Тусгаарлагдах иргэдийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэн, байрны бэлэн байдлыг хангаж ажиллахыг “Өвөр жанчивлан” рашаан сувиллын газрын дарга удирдлагад даалгасугай.

3. Тусгаарлан ажиглах байрны халдвар хамгаалал, бэлэн байдалд үзлэг шалгалт хийж заавар зөвлөмж өгч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР